



INTERNATIONAL MONETARY FUND

*Public Information Notice*

EXTERNAL  
RELATIONS  
DEPARTMENT

Олон нийгэд зориулсан мэдэгдэл №12/131  
ШУУД ТҮГЭЭХ  
2012 оны 11-р сарын 21

Олон Улсын Валютын Сан  
700 19-р гудамж, NW  
Вашингтон хот, КТ 20431 АНУ

**ОУВС-гийн Дүрмийн 4-р заалтын 2012 оны зөвлөлдөх хэлэлцүүлэг,  
хөтөлбөрийн дараах гурав дахь удаагийн хяналтын тайланг  
ОУВС-гийн Захирлуудын зөвлөл хэлэлцэж баталлаа**

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Захирлуудын зөвлөл Дүрмийн 4-р заалтын дагуу Монгол Улстай хийсэн 2012 оны зөвлөлдөх хэлэлцүүлэг<sup>1</sup>, Стэнд-бай хөтөлбөрийн дараах гурав дахь удаагийн хяналтын тайланг<sup>2</sup> 2012 оны 11-р сарын 16-ны өдөр хэлэлцэж баталлаа.

**Үндсэн мэдээлэл**

Монгол Улсын эдийн засгийн хөгжил ахиц дэвшил арвин байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн уул уурхайн салбарын хөгжил эдийн засгийн өсөлтийг түрж, сүүлийн арван жилд эдийн засаг жилд дунджаар найман хувиар өссөн нь бүс нутагтаа тэргүүн үзүүлэлтүүдийн нэг болж байна. Үүний үр дүнд нэг хүнд ногдох ДНБ тав дахин өсч, 3,000 ам. доллар орчимд хүрч, Монгол Улс дэлхийн хөрөнгийн заххаас хөрөнгө босгох боломжтой болсон. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2010 онд батлагдсан), Төсвийн тухай хууль (2011 онд батлагдсан), Нийгмийн халамжийн тухай хуулийн (2012 онд батлагдсан) хүрээнд төсвийн зарцуулалтын хүрээг оновчтой тодорхойлж, байгалийн

---

<sup>1</sup> ОУВС-гийн Дүрмийн 4-р заалтын дагуу ОУВС гишүүн орнуудтайгаа хоёр талын зөвлөлдөх хэлэлцүүлэг явуулдаг бөгөөд гол төлөв нэг жилийн давтамжтай байдаг. ОУВС-гийн ажлын хэсэг гишүүн оронд очиж, эдийн засаг, санхүүгийн мэдээ мэдээллийг цуглуулан, тус улсын эдийн засагт гарсан өөрчлөлт дэвшил, хэрэгжүүлж буй бодлогын талаар албаны хүмүүстэй уулзаж санал солилцдог. Хэлэлцүүлгийг дүгнэн, ажлын хэсэг тайлан гаргаж, Захирлуудын зөвлөлд танилцуулдаг. Захирлуудын зөвлөл тайланг хэлэлцсэний дараагаар Захирлуудын зөвлөлийн дарга буюу ОУВС-гийн Гүйцэтгэх захирал гишүүдийн байр суурийг тоймлон танилцуулдаг. Гүйцэтгэх захирлын энэхүү тойм танилцуулгыг гишүүн орны эрх баригчдад хүргүүлдэг. Тойм танилцуулгыг бэлтгэхэд тавьдаг шалгуурын тайлбарыг доорх хаягаар үзэж болно: <http://www.imf.org/external/np/sec/misc/qualifiers.htm>.

<sup>2</sup> Хөтөлбөрийн дараах хяналтын хүрээнд ОУВС-тай хамтран хөтөлбөр хэрэгжүүлж дууссан боловч зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаа гишүүн орнуудтай ОУВС илүү ойр давтамжтай хэлэлцүүлэг явуулдаг. Ийм төрлийн хэлэлцүүлэг нь гишүүн орны гадаад төлбөр даах чадварт нөлөөлж болзошгүй бодлогын хүрээнд төвлөрдөг. Өөрийн квотын 200-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний зээлийн өрийн үлдэгдэлтэй гишүүн оронд хөтөлбөрийн дараах хяналт тавих бодлого баримталдаг.

нөөцийн зохистой удирдлага, голланд өвчин зэрэг дунд хугацааны гол сорилтуудтыг шийдвэрлэхэд эрх баригчид анхаарч байна.

Эдийн засаг 2011 онд маш их хурдацтай өссөн бөгөөд 2012 оны эхний есөн сарын байдлаар эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувь болж, 2011 оны 17 хувийн өсөлтөөс буурлаа. Нүүрс, зэсийн өсөн нэмэгдэж байгаа олборлолт, уул уурхайн томоохон шинэ төслүүдэд явагдаж буй бүтээн байгуулалт, өвөлжилт харьцангуй өнөтэй болж, хөдөө аж ахуйн салбарыг дэмжиж өгсөн, төсвийн хэт тэлсэн бодлого зэрэг нь өсөлтийг тэтгэгч гол хүчин зүйлсүүд болж байна.

Үүнтэй зэрэгцээд, инфляци өндөр хэвээр байгаагаас гадна гадаад төлбөрийн тэнцэл дарамт ачаалал ихтэй байна. Инфляци 15 орчим хувьтай байгаа нь төсвийн зарцуулалт эрчимтэй өсч байгаатай үндсэндээ холбоотой. Дотоодын эрэлт өндөр байгаагаас импорт нэмэгдэж, улмаар төлбөрийн тэнцэл дээр ирж буй дарамт ачаалал гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал татарч, экспортын өсөлт саарч байгаатай давхцсан. БНХАУ-д гаргасан нүүрсний экспорт сүүлийн саруудад огцом багасч, БНХАУ-ын нийт импорт саарч байгаа үед таарлаа.

Мөнгөний бодлогын хувьд эрх баригчид чангаруулах байр суурь баримталсан. Инфляци сүүлийн 12 сард 10 хувиас хэтрүүлэхгүй гэсэн бодлогын зорилтот түвшингээс нилээд дээгүүр байсан учраас төв банк бодлогын хүү, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг өсгөсөн. Эдгээр бодлого арга хэмжээний үр дүнд зээлийн өсөлт үлэмж саарч, 2011 онд 72 хувиар өсч байсан зээл 2012 оны 9-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хувийн өсөлттэй болсон байна.

Гэвч төсвийн бодлого хэт тэлсэн хэвээр байв. Төсвийн нийт алдагдал 2011 онд ДНБ-ий 5½ хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэгдэж, ДНБ-ий 4¾ хувьд хүрсэн. Уул уурхайн салбарын бүтээн байгуулалттай холбоотой импортоор орж ирж байгаа машин механизм, тоног төхөөрөмжинд ногдуулсан гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын ачаар төсвийн орлого үлэмж нэмэгдсэн. Гэвч орлогын энэхүү өсөлтөөс илүүтэйгээр төсвийн зарлага 62 гаруй хувиар нэмэгдсэн. Төсвийн зарлагын өсөлт 2012 оны эхний хагаст ч өндөр хэвээр байв.

Төгрөгийн ам. доллартай харьцах өнгөрсөн хугацаанд долоон хувиар суларсан бол үүнтэй зэрэгцээд гадаад валютын цэвэр нөөцийн хэмжээ гуравны нэгээр (0.7 сая ам. доллараар) багасч, сүүлийн хоёр жилийн хамгийн доогуур үзүүлэлт буюу 1.5 сая ам. доллар болсон. Монголбанкны БНХАУ-ын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн хүрээнд зээлсэн 200 сая ам. доллартай тэнцэх юанийн, Монгол Улсын Хөгжлийн банкны байршуулсан 400 сая ам. долларын, арилжааны банкуудын 200 сая ам. долларын эх үүсвэрүүд нийлээд гадаад валютын нийт нөөцийн төлбөрийн тэнцэл дээр үзүүлэх нөлөөллийг сааруулсан. Гадаад валютын нийт нөөцөд одоогоор 2.6 тэрбум ам. доллар (уул уурхайн бус импортын 6.3 сар) байгаа нь түүхэн өндөр үзүүлэлт юм.

Эдийн засгийн өсөлтийн ойрын үеийн төлөв байдал таатай байгаа боловч инфляци 10 хувиас буурахгүй байх тооцоо гарч байна. Төлбөрийн тэнцлийн дарамт ачаалал

буурахааргүй харагдаж байна. Гэвч нүүрсний экспортын хүчин чадал улам бүр нэмэгдэж, зэсийн экспорт өсөх төлөвтэй байна. Хөгжлийн банкны санхүүжилттэй нийтийн зориулалттай хөрөнгө оруулалтын төслүүд хэрэгжиж, импортыг улам нэмэгдүүлэх болно.

Монгол Улсын дунд хугацааны төлөв ихийг амлаж байна. Нүүрс, зэсийн олборлолт нэмэгдэж, уул уурхайн салбарыг дагасан үйл ажиллагаа мөн идэвхжих болно. Гэхдээ бизнесийн орчинг боловсронгуй болгоход чиглэсэн шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байх болно.

Шинэчлэлийн Засгийн газар 2012-2016 оны мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан хэд хэдэн асуудлуудыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байна. Засгийн газрын бодлогод дэлхийн эдийн засгийн төлөв байдал тодорхой бус хэвээр байгааг харгалзаж үзэх нь чухал болжээ. Энэ байдлаас гарч болох үр дагавар асар их бөгөөд Монгол Улсын хувьд экспортын биет хэмжээ, экспортын гол бүтээгдэхүүний үнэ, гадаадын хөрөнгө оруулалтын дотогшлох урсгалд нөлөөлөх болно.

### **Захирлуудын зөвлөлийн үнэлгээ**

Монгол Улс сүүлийн жилүүдэд эдийн засгийн өндөр өсөлтөнд хүрч чадсаныг Захирлуудыг зөвлөл магтан сайшаахын хажуугаар өсөлтийг илүү хүртээмжтэй болгоход анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Ойрын хугацаанд тулгарах бодлогын хамгийн том сорилт бол хөрөнгө оруулалтын асар их хэрэгцээг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэхэд анхаарах явдал юм. Боловсронгуй болгоод удаагүй байгаа төсвийн харилцааны хууль эрх зүйн зохицуулалт нь энэхүү зорилгод дэмжлэг болно гэдэг дээр Захирлуудын зөвлөлийн гишүүд санал нэгдлээ.

Монгол Улсын эдийн засгийн төлөв дунд хугацаанд нааштай байгаа хэдий ч инфляцийн түвшин буурахгүй, дотоодын эрэлт эрчимтэй өсч байгаа нь гадаад төлбөрийн тэнцэл дээр дарамт үүсгэж байгааг мөн онцлон тэмдэглэв. Ийм нөхцөл байдалд төсвийн бодлогыг хумиж, дотоод болон гадаад тогтвортой байдлыг хангахад 2013 оны төсөв шийдвэрлэх ач холбогдолтой болохыг анхаарууллаа. Иймд, Монгол Улсын эрх баригчид 2013 оны төсвийг боловсруулж хэрэгжүүлэхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг, түүний дотор төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал ДНБ-ий хоёр хувиас хэтрэхгүй байх заалтыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөхийг уриаллаа. Төсвийн орлогын төлөвлөгөө тасарч болзошгүй, гадаад орчин тодорхой бус байгаа энэ үед төсвийн орлогын төсөөллийг гаргахдаа хариуцлагатай хандаж, тэвчиж болох хөрөнгө оруулалтын зардлыг хойшлуулах замаар зарлагыг багаар төлөвлөхийг зөвлөв.

Монгол Улсын Хөгжлийн банк дэд бүтцийн урт хугацааны эрэлт хэрэгцээг макро эдийн засгийн хувьд тогтвортой байдлаар, төсөвт аль болох бага эрсдэл учруулахаар хангах бодлогыг тодорхой болгох шаардлагатай байгааг онцлов. Нэн ялангуяа, төсвийн бодлогын зорилтыг тодорхойлохдоо шинээр тогтоосон төсвийн харилцааны зохицуулалттай уялдуулан Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих нийтийн зориулалттай төслүүдийг тооцоо судалгаанд харгалзан үзэх нь зүйтэй. Эрх баригчид үндэсний баялгийн сан байгуулах

талаар судалгаа хийж байгааг сайшааж, энэ нь төсвийн тогтолцоог бэхжүүлэх чухал бүрэлдэхүүн болох боломжтойг тэмдэглэв.

Өнгөрсөн хугацаанд мөнгөний бодлогыг чангаруулсан нь зүйтэй алхам байсан гэж Захирлын зөвлөлийн гишүүд үзлээ. Инфляцийн түвшин эрх баригчдын тогтоосон бодлогын зорилтот түвшингээс давсан хэвээр байгаа учраас төсвийн бодлогыг хумиж, инфляцийн дарамт сулрахаас наана мөнгөний бодлогыг зөөллөх боломж харагдахгүй байна гэж үзлээ. Гадаад валютын ханш зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр зохицуулагдан хөдлөж байх бодлогыг эрх баригчид тууштай барих болсныг сайшаан дэмжив. Гэхдээ, төсвийн бодлого тэлсээр байгаа нь гадаад валютын цэвэр нөөц багасахад түлхэц болж байгаагийн дээр энэ байдал удаан үргэлжилвэл даацгүй болохыг онцлон тэмдэглэв.

Санхүүгийн салбарыг бэхжүүлж, гүнзгийрүүлэх чиглэлээр эрх баригчдын авч байгаа арга хэмжээг дэмжиж, түүний дотор системийн ач холбогдолтой банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг шат дараатайгаар өсгөх шийдвэрийг сайшаав. Цаашид засгийн газрын үнэт цаасны захыг хөгжүүлэх, банкны салбарын эрсдэлүүд, түүний дотор гадаад валютаар олгогдож байгаа, эрсдэлийн хамгаалалтгүй зээлээс үүдэлтэй эрсдэлийг бууруулах, гадаад валютын захыг гүнзгийрүүлэх, мөнгөний бодлогын дамжуулах сувгийг боловсронгуй болгох, мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд байгаа согог дутагдлыг арилгах чиглэлээр нэмж арга хэмжээ авахыг зөвлөлөө. Эдийн засгийг төрөлжүүлэх зорилгоор бизнесийн орчныг бэхжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах хууль эрх зүйн орчныг тодорхой болгох чиглэлээр авч хэрэгжүүлж буй шинэчлэлийг үргэлжлүүлэхийн ач холбогдолыг онцлон тэмдэглэв.

**Олон нийтэд зориулсан мэдэгдэл** нь ОУВС-гийн байр суурь, гишүүн орны эдийн засагт гарч буй өөрчлөлт дэвшил, бодлогод хийсэн дүн шинжилгээг олон нийтэд ил тод болгохтой холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Дүрмийн 4-р заалтын дагуу гишүүн оронтой хийдэг зөвлөлдөх хэлэлцүүлэг, бүс нутгийн хэмжээнд гарч байгаа өөрчлөлтөнд хийсэн хяналт шинжилгээ, хөтөлбөрийн дараах үнэлгээ, урт хугацааны хөтөлбөртэй байгаа улсуудын хувьд хөтөлбөрийн дараах хөндлөнгийн хяналт үнэлгээний үр дүнг Захирлуудын зөвлөлийн хурлаар авч хэлэлцсэний дараагаар тухайн улс буюу улс орнуудын зөвшөөрөлтэйгээр энэхүү мэдэгдлийг гаргадаг. Мөн түүнчлэн, Захирлуудын зөвлөл дээр хийгдсэн бодлогын ерөнхий асуудлуудын талаарх хэлэлцүүлгийн дүгнэлтийг ийнхүү олон нийтэд танилцуулдаг бөгөөд зарим тохиолдолд асуудлын агуулгаас хамаарч Захирлуудын зөвлөл олон нийтэд мэдээлэл хүргэх шаардлагагүй гэж үзэж болно.

## Монгол Улс: Эдийн засаг, санхүүгийн зарим үзүүлэлтүүд, 2009–2013

	2009	2010	2011	Төсөөлөл	
				2012	2013
<b>Бодит салбар (өөрчлөлт, хувиар)</b>					
ДНБ-ий бодит өсөлт	-1.3	6.4	17.5	11.2	16.8
Эрдэс баялгийн	0.2	7.4	11.2	6.8	50.6
Эрдэс баялгийн бус	-1.8	6.0	19.9	12.8	5.4
Хэрэглээний үнэ (хугацааны дундаж)	6.3	10.2	7.7	14.1	10.9
Хэрэглээний үнэ (хугацааны эцэст)	1.9	14.3	9.4	12.9	10.2
ДНБ-ий дефлятор	1.8	20.0	12.1	10.0	8.9
<b>Нэгдсэн төсөв (ДНБ-д эзлэх хувиар)</b>					
Нийт орлого, тусламжийн дүн	30.3	37.1	40.3	37.1	35.2
Нийт зарлага, цэвэр зээл	35.5	36.6	45.1	42.3	37.6
Урсгал тэнцэл	2.8	9.8	11.0	5.1	9.3
Суурь тэнцэл	-4.7	1.0	-4.4	-4.1	-0.5
Нийт тэнцэл (тусламжийн дүнг оруулаад)	-5.2	0.5	-4.8	-5.2	-2.4
Эрдэс баялгийн бус нийт тэнцэл	-10.2	-7.0	-14.3	-12.2	-9.7
Тэнцвэржүүлсэн тэнцэл 1/	...	...	-6.9	-6.0	-3.1
<b>Мөнгө, зээлийн үзүүлэлт (өөрчлөлт, хувиар)</b>					
Нийт мөнгө	26.9	61.6	37.1	28.8	27.2
Нийт мөнгөний эргэц (ДНБ/Нийт мөнгө)	2.3	1.8	1.7	1.7	1.7
Төв банкны 7- хоногтой үнэт цаасны хүү, хугацааны эцэст (хувиар)	10.0	11.0	12.3	...	...
<b>Төлбөрийн тэнцэл (сая ам. доллар)</b>					
Урсгал дансны тэнцэл (албан ёсны шилжүүлгийг оруулаад)	-410	-931	-2,774	-3,605	-2,839
(ДНБ-д эзлэх хувиар)	-9.0	-14.9	-31.8	-36.3	-24.1
(ДНБ-д эзлэх хувиар, уул уурхайн холбогдолтой импортыг хасаад)	-5.8	-5.7	-11.3	-16.7	-6.7
Гадаад худалдааны тэнцэл	-194	-278	-1,008	-1,840	-983
Экспорт	1,876	2,899	4,780	4,420	5,811
Импорт	-2,070	-3,177	-5,788	-6,260	-6,794
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	496	1574	4,620	2,789	1,907
Гадаад валютын нийт нөөц (хугацааны эцэст)	1,328	2,288	2,447	2,319	2,273
(бараа үйлчилгээний дараа оны импортын сараар)	4.0	3.6	3.6	3.2	3.2
<b>Гадаад худалдааны үнэ</b>					
Экспортын үнэ (ам. доллар, өөрчлөлт, хувиар)	-8.2	3.7	8.3	-0.5	-0.5
Импортын үнэ (ам. доллар, өөрчлөлт, хувиар)	-14.1	8.8	13.1	-0.7	-1.5
Гадаад худалдааны нөхцөл (өөрчлөлт, хувиар)	6.9	-4.7	-4.3	0.2	1.0
<b>ЗГ-ын болон ЗГ-ын баталгаатай өр (ДНБ-д эзлэх хувиар)</b>					
Нийт улсын өр	46.6	45.3	51.7	56.7	54.2
Дотоод өр 2/	3.4	16.3	25.6	27.4	23.9
Гадаад өр	43.2	28.9	26.1	29.4	30.2
(сая ам. доллар)	1,974	1,938	2,074	2,775	3,492
<b>Ханш</b>					
Төгрөгийн ам. доллартай харьцах (хугацааны эцэст)	1,443	1,257	...	...	...
Төгрөгийн ам. доллартай харьцах (хугацааны дундаж)	1,441	1,348	...	...	...
Үйлчилж буй нэрлэсэн ханш (хугацааны эцэст; өөрчлөлт, хувиар)	-15.8	3.4	...	...	...
Үйлчилж буй бодит ханш (хугацааны эцэст; өөрчлөлт, хувиар)	-11.2	11.2	...	...	...
ДНБ оны үнээр (тэрбум төгрөг)	6,591	8,415	11,088	13,566	17,257

Эх сурвалж: Монгол Улсын эрх бүхий байгууллагууд; ОУВС-гийн мэргэжилтнүүдийн тооцоо судалгаа.

1/ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд заасны дагуу, төсвийн орлого тооцоход экспортын гол бүтээгдэхүүний бодит үнийг бус тэнцвэржүүлсэн үнийг ашигладаг.

2/ 2009-2011 онуудын дотоод өр Оюутолгойн татварын урьдчилгааг багтаасан байгаа.